Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2022 онд нийт 115 төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, давхардсан тоогоор 216 нэгжийг хамруулжээ. Үүнээс төлөвлөгөөт 115, Сангийн сайдын удирдамжаар 2, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр болон иргэдийн өргөдөл гомдлоор 37 шалгалт хийж, дүгнэлт гаргасан байна. Мөн аймгийн Цагдаагийн газрын Шүүх нягтлан бодох бүртгэлийн шинжээчээр томилсон тогтоолоор 2 байгууллагад шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

Хяналт шалгалтын дүнгээр нийтдээ 76.0 сая төгрөгийн акт тогтоож, үүнээс орон нутгийн төсөвт 53.4 сая төгрөг оруулж, 2.0 сая төгрөгийг улсын төсвийн орлогод, 20.6 сая төгрөгийг хувь хүнд эргүүлэн нөхөн төлүүлэхээр тогтоосон байна. Тайлант онд өмнөх онд төлөгдөөгүй актаас 6.9 сая төгрөг, тайлант оны актаас 42.1 сая төгрөг, бүгд 49.0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан байна.

Мөн 29 байгууллага, аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг хангуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймаг, сумын төрийн сан, Санхүүгийн албаны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг өдөр тутмын хяналт, төлөвлөгөөт хяналт, төлөвлөгөөт бус хяналт гэсэн хэлбэрээр явуулж ирсэн байна.

Өдөр тутмын хяналтаар Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан төрийн санд харьяалах төсөвт байгууллагуудын орлого, зарлагын хуулгыг өдөр бүр шалган буцсан гүйлгээ болон орлого бууруулах гүйлгээг хянаж, илэрсэн зөрчлийг холбогдох сумуудын санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, төлбөр тооцооны мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч тухай бүр арилгуулан ажилласан байна.

Төлөвлөгөөт хяналтаар: Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалтуудыг зөрчиж ажилласан Бугат, Баяннуур, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумуудын төрийн сан, санхүүгийн албанд зөвлөмж өгч, Алтанцөгц, Өлгий сумын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаа хэвийн явагдсан талаар хяналт шалгалтын дүнг гаргаж ажилласан байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тайлант онд боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр 2022 оны 12 дугаар сарын 31-нээр хасагдаж, оны эхний 1-4-н сарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлс, орон нутгийн төсвөөс олгогддог тогтмол зардлууд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж орсон байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118,526.3 сая төгрөгөөр буюу 54.8 хувиар буурсан байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,608.7	6,717.1	(1,891.7)
Авлага	6,331.9	6,758.3	426.4
Урьдчилж гарсан зардал	12.3	46.9	34.6
Бараа материал	5,791.9	1,325.4	(4,466.6)
Нөөцийн бараа	57.8	174.5	116.8
Үндсэн хөрөнгө	195,553.9	82,808.1	(112,745.8)
Нийт хөрөнгө	216,356.6	97,830.3	(118,526.3)
Өр төлбөр	5,444.6	5,956.9	512.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	210,912.0	91,873.4	(119,038.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	216,356.6	97,830.3	(118,526.3)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Дээрх их хэмжээний өөрчлөлт нь боловсрол, соёл, эрүүл мэндийн салбар болон бусад салбарын зарим байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 6,717.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,891.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	5.3	4.7	(0.6)
Банканд байгаа бэлэн мөнгө	8,603.4	6,712.4	(1,891.1)
Төгрөг	8,603.4	6,712.4	(1,891.1)
Төрийн сангийн харилцах	7,776.2	5,060.0	(2,716.2)
Арилжааны банк дахь харилцах	827.1	555.1	(272.0)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.1	2.1	
Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	1,095.2	
Дүн	8,608.7	6,717.1	(1,891.7)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	1,862.9	3,211.2	1,348.3
Төсөл/ сан	4,276.3	1,724.3	(2,552.0)
Төрийн сан	1,716.2	1,320.7	(395.5)
ТӨҮГ болон ОНӨҮГ	753.3	460.9	(292.4)
Дүн	8,608.7	6,717.1	(1,891.7)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө дансны бууралт нь оны эхний үлдэгдэл болон тайлант оны зарцуулалттай холбоотой байна.

Оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 5.3 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 8,603.4 сая төгрөг нь банкинд байгаа бэлэн мөнгө байна.

Оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 4.7 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 6,712.4 сая төгрөг нь банкинд байгаа бэлэн мөнгө байна. Банканд байршиж буй 6,712.4 сая төгрөгт гадаад валютаар байршсан мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Банкинд байгаа 6,712.4 сая төгрөгийн 5,060.0 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл, 2.1 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн харилцах, 555.1 сая төгрөг нь арилжааны банк, 1,095.2 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн арилжааны банкны үлдэгдэл байна.

Үүнээс 3,211.2 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 1,724.3 сая төгрөг нь төсөл сангийн, 1,320.7 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 460.9 сая төгрөг нь ОНӨҮГ-уудын дансны үлдэгдэл байна.

Нэмэлт санхүүжилтийн арилжааны банкин дахь 1095.2 сая төгрөгийг үлдэгдэл нь Түлш эрчим хүчний яамнаас “Эрдэнэбүрэн усан цахилгаан станц”-ын төслөөр Баяннуур сумын 51 айл

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

өрхийн нөхөн олговрын санхүүжилтийг Аймгийн ЗДТГ-ын дансаар дамжуулан олгосон, дансны үлдэгдэл байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн харилцахын эхний үлдэгдэл 7,776.3 сая төгрөг байснаас 1,619.0 сая төгрөгөөр буурч оны эцэст 6,157.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө			
Төгрөг			
Нэмэлт санхүүжилт			
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг			
Төрийн сан	7,776.2	5,060.0	(2,716.2)
Арилжааны банкин дахь харилцах			-
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.1	2.1	2.0
Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		1,095.2	1,095.2
Нийт дүн	7,776.30	6,157.30	(1,619.00)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6,157.3 сая төгрөгийг задруулбал: 1,360.1 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны, 1,281.0 сая төгрөг нь ОНХС-ийн, 744.0 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, 21.1 сая төгрөг нь Замын сангийн, 956.6 сая төгрөг нь Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл, 672.7 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн мөнгө, 24.4 сая төгрөг нь сумдын БОХНСТС барьцаа дансны үлдэгдэл, 2.2 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар нь Арилжааны банкны харилцах дансны үлдэгдлийг 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 6,758.3 сая төгрөг болж, өмнөх оноос 426.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
			/сая төгрөгөөр/
Ажиллагчтай холбогдсон авлага	68.4	12.7	(55.7)
Төлбөртэй үйлчилгээний авлага	723.1	219.1	(504.0)
Татаас, санхүүжилтийн авлага	-	313.3	313.3
Зээлийн хүүгийн авлага	17.2	31.5	14.2
Дансны авлага /ТӨҮГ/	6.5	6.5	-
Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	0.1	0.1
Бусад авлага	1,793.9	2,408.0	614.1
Байгууллагаас авах авлага	1,137.2	2,215.6	1,078.4
Хувь хүмүүсээс авах авлага	656.8	192.5	(464.3)

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зээлийн авлага	3,722.8	3,767.0	44.3
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	250.4	250.4	-
Хувь хүмүүст олгосон зээл	3,472.4	3,516.6	44.3
Дүн	6,331.9	6,758.3	426.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	3,066.4	2,291.9	(774.5)
Төсөл/ сан	1,320.8	1,366.0	45.2
Төрийн сан	256.8	926.1	669.3
ОНӨҮГ	1,688.0	2,174.3	486.3
Дүн	6,331.9	6,758.3	426.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 147.7 сая төгрөгөөр өссөн нь татаас, санхүүжилтийн авлага 313.3 сая, зээлийн хүүгийн авлага 14.2 сая, татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ авлага 0.1 сая, байгууллагаас авах авлага 1,078.4 сая, хувь хүмүүст олгосон зээлийн авлага 44.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ажиллагсадтай холбоотой авлага 55.7 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 504.0 сая, хувь хүмүүсээс авах авлага 464.3 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт авлагын үлдэгдлийн 33.9 хувийг төсөвт байгууллагын, 20.2 хувийг төсөл сангийн, 13.7 хувийг төрийн сангийн, 32.2 хувийг аж ахуйн нэгжүүдийн авлага эзэлж байна.

Төсөвт байгууллагуудын авлага 774.5 сая төгрөгөөр буурч, төсөл сангуудын авлага 45.2 сая, төрийн сангийн авлага 669.3 сая, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн авлага 486.3 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Төсөвт байгууллагуудын авлагын үлдэгдэл өмнөх оноос 774.5 сая төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр шилжсэн байгууллагуудын авлагатай холбоотой.

Орон нутгийн төсөвт байгууллагуудаас оны эцэст Алтанцөгц, Сагсай сумын ЗДТГ, Дэлүүн, Улаанхус, Өлгий сумын ИТХ, Сум дундын ойн анги зэрэг байгууллагууд 0.1-27.8 сая төгрөгөөр шинээр авлага үүсгэсэн байна.

Төрийн сангийн авлагын дансны үлдэгдэлд Дэлүүн сумын Орон нутгийн ерөнхий орлогын 3.0 сая, Баяннуур сумын Орон нутгийн ерөнхий орлогын 3.4 сая, аймгийн Орон нутгийн ерөнхий орлогын 250.4 сая төгрөгийн он дамжсан авлагууд барагдаагүй, тайлант онд шинээр 304.4 сая төгрөгийн сумдаас аймагт төвлөрүүлэх тэгшитгэлийн авлага, орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны урт хугацаат зээлийн өглөгийн төлбөрт 364.9 сая төгрөгийн Сангийн яамнаас аймагт олгох санхүүгийн дэмжлэгээс суутган төлүүлснийг авлагаар бүртгэсэн нь авлага нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Сумуудын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Ногооннуур, Толбо, Цэнгэл сумуудад 21.7-89.0 сая төгрөгөөр буурч, Булган, Буянт, Дэлүүн, Сагсай, Өлгий сумуудад 16.2-143.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлагын үлдэгдэл нэмэгдсэн нь зээлийн эргэн төлөлтөөс шинээр зээл олгосонтой холбоотой байна.

Оны эцэст Алтанцөгц, Булган сумын ОНХС авлагатай гарч, Дэлүүн сумын ОНХС оны эхний авлагаа барагдуулсан байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ОНӨҮГ-уудын авлага өмнөх оноос 486.3 сая төгрөгөөр өссөн нь ЦШСГ-ын авлага 619.0 сая, “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын авлага 0.07 сая төгрөгөөр нэмэгдэж, “Суат” ХХК-ний авлага өмнөх оноос 59.4 сая төгрөгөөр буурчээ.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Цахилгаан шугам сүлжээний газар нь 2022 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 66.2 төгрөгийн зөрчлийг тус газрын дарга, ерөнхий нягтлан бодогч нараар нөхөн төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоосны 46.2 сая төгрөгийг байгууллагын данснаас төлж барагдуулсан боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, зардалд бичсэн.
- Хятад улсаас сэлбэг, материал худалдан авах зорилгоор 2022 онд 88.8 сая төгрөгийг гэрээгүй, бүрдэл дутуу баримтаар шилжүүлж, авлагаар тайлагнасан боловч биетээр хүлээж аваагүй зөрчилд албан шаардлага өгөгдсөн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 46.9 сая төгрөг болж, өмнөх оноос 34.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	12.3	46.9	34.6
Урьдчилгаа тооцоо			
Дүн	12.3	46.9	34.6

Эх сурвалж: Аудитын судалгаа

“Суат” ХХК урьдчилгаа дансанд 2016 онд бүтгэгдсэн 12.3 сая төгрөгийн төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь барагдаагүй, тайлант онд шинээр 0.8 сая төгрөгийн зардал нэмэгдэж 13.1 сая төгрөгийн, БОАЖГ нь жилийн эцэст 33.7 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тайлагнасан ба үүнээс 28.7 сая төгрөг нь “ПГЖМ” ХХК-аас нийлүүлэх тракторын үнийн 50 хувь, 5 сая төгрөг нь “Ранго-трэйбл” ХХК-ийн отоглох хоноглох цэг барихтай холбоотой урьдчилж гарсан зардлыг бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Урьдчилж гарсан зардал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны оны эхний үлдэгдэл 5849.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1499.9 сая төгрөг болж, оны эхнээс 4349.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БАРАА МАТЕРИАЛ	5,791.8	1,325.4	(4,466.4)
Түүхий эд материал	456.7	252.4	(204.3)
Тусгай зориулалттай материал	150.6	52.0	(98.6)

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эм боох материал	306.1	200.4	(105.7)
Бэлэн бүтээгдэхүүн	45.5	0.3	(45.2)
Хангамжийн материал	5,095.5	972.9	(4,122.6)
Бичиг хэргийн материал	86.3	10.3	(76.0)
Аж ахуйн материал	2,432.2	417.8	(2,014.4)
Сэлбэг хэрэгсэл	236.2	195.5	(40.7)
Түлш, шатах тослох материал	126.0	16.2	(109.8)
Барилгын засварын материал	6.0	-	(6.0)
Хүнсний материал	712.5	5.7	(706.8)
Бусад хангамжийн материал	1,496.3	327.4	(1,168.9)
Мал амьтад	194.1	99.8	(94.3)
Нөөцийн бараа	57.8	174.5	116.7
Дүн	5,849.6	1,499.9	(4,349.7)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5,405.0	866.3	(4,538.70)
Төсөл/ сан			
Төрийн сан			
ОНӨҮГ	444.6	633.6	189.00
Дүн	5,849.6	1,499.9	(4,349.7)

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 57.8 хувийг буюу 866.3 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын, 42.2 хувийг буюу 633.6 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2707.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 241.6 сая төгрөгийн материал хүлээн авч, 2687.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2.3 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, 4609.3 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж данснаас хасжээ.

Үүнээс төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 1366.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 152.0 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, 1369.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2.3 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, 4609.3 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж данснаас хасжээ.

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд 1314.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1318.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, оны эцэст 440.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Төсөвт байгууллагууд оны эцэст 3.9 сая төгрөгийн тусгай зориулалтын, 104.4 сая төгрөгийн эм боох, 6.2 сая төгрөгийн бичиг хэргийн, 338.7 сая төгрөгийн аж ахуйн, 1.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн, 15.4 сая төгрөгийн түлш шатах тослох, 314.7 сая төгрөгийн бусад хангамжийн материалын, 0.3 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний, 99.9 сая төгрөгийн мал амьтад, 174.5 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд оны эцэст 440.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй бөгөөд үүний 48.1 сая төгрөг нь тусгай зориулалтын, 95.9 сая төгрөг нь эм боох, 4.1 сая төгрөг нь бичиг хэргийн, 79.1 сая төгрөг нь аж ахуйн, 193.7 сая төгрөг нь сэлбэг хэрэгсэл, 0.8 сая төгрөг нь түлш, шатах тослох, 5.7 сая төгрөг нь хүнсний, 12.7 сая төгрөг нь бусад хангамжийн материал байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн захирагчдын ангиллаар авч үзвэл Алтай сум 26.8 сая төгрөгийн, Алтанцөгц сум 31.0 сая төгрөгийн, Баяннуур сум 3.0 сая төгрөгийн, Булган сум 103.1 сая төгрөгийн, Буянт сум 22.2 сая төгрөгийн, Дэлүүн сум 167.7 сая төгрөгийн, Ногооннуур сум 67.1 сая төгрөгийн, Сагсай сум 77.0 сая төгрөгийн, Толбо сум 62.8 сая төгрөгийн, Улаанхус сум 32.1 сая төгрөгийн Цагааннуур тосгон 8.6 сая төгрөгийн, Цэнгэл сум 87.2 сая төгрөгийн, Өлгий сум 215.8 сая төгрөгийн, бусад байгууллагууд 595.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Дэлүүн сумд 64.5 сая төгрөгийн, Сагсай сумд 27.3 сая төгрөгийн, Цэнгэл сумд 82.7 сая төгрөгийн, нийт 174.5 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- *Алтай сумын Засаг даргын тамгын газар 182.0 сая төгрөгийн, Булган сумын Засаг даргын тамгын газар 104.6 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.*
- *Улаанхус сумын Засаг даргын тамгын газар шатахуун 8.2 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.*
- *Өлгий сумын Засаг даргын тамгын газар тээвэр шатахууны зардалд зарцуулсан 12.2 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 16.4 сая төгрөгийн шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй, шатахуун зарцуулалтын тооцоог хийж баримтжуулаагүй.*
- *Өлгий сумын "Раушан", "Шипагер", "Жансая", "Мейрим" өрхийн эрүүл мэндийн төвүүд нь 193.0 сая төгрөгийн бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг тооцоо хийж тулган баталгаажуулаагүй, нярвын агуулахын бүртгэл хөтлөөгүй, бараа материалын тайланг гаргаагүй байна.*

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн барааны үлдэгдэл 174.5 сая төгрөгийн болж, 116.8 сая төгрөгөөр өссөн нь Дэлүүн, Сагсай, Цэнгэл сумуудын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн тэжээлийн нөөцийн дүнгээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгийн буюу Нөөцийн бараа үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	57.8	174.5	116.8
Тэжээлийн нөөц	57.8	174.5	116.8
Дүн	57.8	174.5	116.8

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 82,808.1 сая төгрөг болж, өмнөх оноос 112,745.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	185,427.4	74,188.2	(111,239.2)
Барилга, байгууламж, орон сууц	126,624.6	24,327.7	(102,297.0)
Авто-тээврийн хэрэгсэл	1,683.5	2,136.3	452.8

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,067.9	10,210.6	(3,857.3)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,508.1	465.1	(2,043.0)
Зам, гүүрийн байгууламж	22,851.8	25,949.0	3,097.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,603.5	5.2	(1,598.2)
Бусад үндсэн хөрөнгө	9,778.8	10,345.9	567.1
Дуусаагүй барилга, байгууламж	4,567.0	744.8	(3,822.2)
Ном	1,742.3	3.7	(1,738.6)
Биет бус хөрөнгө	10,126.5	8,619.9	(1,506.6)
Программ хангамж	33.1	74.0	40.9
Бусад биет бус хөрөнгө	10,093.4	8,545.9	(1,547.5)
Дүн	195,553.9	82,808.1	(112,745.8)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	177,799.7	65,200.7	(112,599.0)
Төсөл/ сан	0.8	0.7	(0.1)
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	17,753.4	17,606.7	(146.7)
Дүн	195,553.9	82,808.1	(112,745.8)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн хөрөнгийн данс 112,745.8 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт үндсэн хөрөнгийн 78.7 хувийг төсөвт байгууллагын, 21.3 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд нийт үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 392.6 сая төгрөгөөр, балансаас балансад шилжүүлэн авсан 689.4 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хандиваар авсан 9,967.8 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 411.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 140,918.7 сая, акталсан 917.8 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансны оны эцсийн үлдэгдэлд 744.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас Алтанцөгц сумд 200.0 сая төгрөгийн, Сагсай сумд 31.8 сая төгрөгийн, Улаанхус сумд 343.0 сая төгрөгийн, Асрамжийн газарт 170.0 сая төгрөгийн дуусаагүй барилга бүртгэлтэй байна.

Эдгээр дуусаагүй барилгаас Асрамжийн газрын 170.0 сая төгрөгийн дуусаагүй барилга нь олон жил он дамжсан барилга, бусад нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 2023 онд ашиглалтад орох барилга, байгууламж байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд нийтдээ 5,355.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өглөгийн данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Өлгий сумын "Раушан", "Шипагер", "Жансая", "Мейрим" өрхийн мэндийн төвүүд нь үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг тооцоо хийж тулган баталгаажуулаагүй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 5444.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5956.9 сая төгрөг болж, оны эхнээс 512.3 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,158.90	3,002.30	843.40
Төрийн өмчит ААН-ийн зээл	-	331.10	331.10
Өглөг	1,892.80	2,090.40	197.60
Урьдчилж орсон орлого	266.10	580.80	314.70
Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,285.70	2,954.60	(331.10)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,127.70	2,796.60	(331.10)
Хувь хүмүүсийн зээл	138.00	138.00	-
Санхүүгийн бусад байгууллага	20.00	20.00	-
Нийт дүн	5,444.60	5,956.90	512.30
<u>Үүнээс байгууллагын төрлөөр</u>			
Төсөвт байгууллага	1,225.90	171.40	(1,054.50)
Төсөл, сан	129.90	939.10	809.20
Төрийн сан	4.90	624.00	619.10
ОНӨҮГазар	4,083.90	4,222.40	138.50
ДҮН	5,444.60	5,956.90	512.30

Эх сурвалж: Аудитын судалгаа

Тайлант онд төсвийн байгууллагуудын өглөг 1054.5 сая төгрөгөөр буурсан бол төсөл сангуудын өглөг 809.2 сая төгрөгөөр, төрийн сангийн өглөг 619.1 сая төгрөгөөр, ОНӨҮГ-ын өглөг 138.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр

Төрийн өмчит ААН-ийн зээлийн өглөг өмнөх оноос 364.9 сая төгрөгөөр өссөн нь Сангийн яам 2022 онд аймгийн орон нутгийн төсөв олгох санхүүгийн дэмжлэгээс “Суат” ХХК-ийн урт хугацаат зээлийн төлбөрт 364.9 сая төгрөгийг суутган төлүүлснийг богино хугацаат өглөгөөр бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр нийтдээ 2090.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс: 133.7 сая төгрөгийн өглөг нь ажилчидтай холбоотой, 57.1 сая төгрөгийн өглөг нь бараа үйлчилгээний зардлын, 314.5 сая төгрөгийн өглөг нь татаас санхүүжилтийн, 1261.6 сая төгрөгийн өглөг нь байгууллагад төлөх, 53.7 сая төгрөгийн өглөг нь хувь хүмүүст төлөх, 197.1 сая төгрөгийн өглөг нь ОНӨҮГ-ын татварын, 30.7 сая төгрөгийн өглөг нь ОНӨҮГ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн, 5.7 сая төгрөгийн өглөг нь дансны өглөг байна.

“Жана-Өлке” ХХК-ны 266.1 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдэлд Сангийн яамнаас 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 314.7 сая төгрөгийг аймгийн төсөвт нэмж хуваарилсныг бүртгэснээр оны эцэст 580.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсөвт байгууллагуудын өглөг өмнөх оноос 1054.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн өглөгтэй холбоотой.

Оны эцэст сумдын Засаг даргын тамгын газрууд нийт дүнгээр 107.9 сая төгрөгийн, Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нийт дүнгээр 18.3 сая төгрөгийн, бусад төсөвт байгууллагуудаас

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ахмадын сан 5.7 сая төгрөгийн, Асрамжийн газар 3.1 сая төгрөгийн БОАЖГ 0.5 сая төгрөгийн, Хот тохижуулах алба 35.9 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Төсөл сангийн өглөг өмнөх оноос 809.2 сая төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөрөнгө оруулалт 27.7 сая төгрөгийн, Замын сан 14.4 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт 618.3 сая төгрөгийн өглөгтэй гарсантай холбоотой.

Өмнөх оны Орон нутгийн хөгжлийн сангийн өглөгөөс Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн сумууд болон Цагааннуур тосгон нийт 61.6 сая төгрөгийг барагдуулсан бол аймгийн Орон нутгийн хөгжлийн сан 10.3 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн.

ОНӨҮГ-ын өглөг оны эхнээс 138.5 сая төгрөгөөр өссөн байна. ЦШСГ 2294.5 сая, “Суат” ХХК 1258.8 сая, “Өлгий Сансар” эмнэлэг 129.4 сая, “Хала-Өркени” ОНӨААТҮГ 22.4 сая, “Жана-Өлке” ОНӨААТҮГ 506.3 сая, Өрхийн эмнэлэг 2.0 сая, Эмийн эргэлтийн сангууд 8.9 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Алтай, Алтанцөгц сумын Эмийн эргэлтийн сан 8.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, Улаанхус сумын Эмийн эргэлтийн сан 5.8 сая төгрөгийн өртэй гарсан бол төрийн сангийн өглөг өмнөх оноос 619.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны эцэст Өлгий сумын орон нутгийн ерөнхий орлого 305.9 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн ерөнхий орлого 314.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь Өлгий сумаас аймагт олгох тэгшитгэл нь орлогын төлөвлөгөө 305.9 сая төгрөгөөр тасарсны улмаас дутуу олгогдсоныг өглөгөөр бүртгэж тайлагнасан байна. Аймгийн ерөнхий орлогод бүртгэж тайлагнасан 314.7 сая төгрөг нь аж ахуйн нэгжийн орлогын нэгдсэн албан татварын 30 хувь нь орон нутагт орох ёстой байсан ба оны эцсээр орлогын төлөвлөгөө тасарснаас Сангийн яамнаас 2023 орлогоос урьдчилж шилжүүлж өгснийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн байна.

Урт хугацаат өр төлбөр

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд нийтдээ 2954.0 сая төгрөгийн урт хугацаат өр бүртгэлтэй байна.

“Суат” ХХК-ийн 2001 оноос хойш үүссэн урт хугацаат зээлээс тайлант онд 364.9 сая төгрөгийг суутган төлүүлсэнтэй холбоотой урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 660.0 сая төгрөг болж оны эхнээс 364.9 сая төгрөгөөр буурчээ.

Энэ нь Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд тус аймагт цэвэр бохир усны системийн техник, технологийг шинэчлэх цэвэр усны шугам хоолойг өргөтгөх, цэвэр бохир усны насосын станц, 30 хүний халуун усны барилгад их засвар хийх, 3 ба 5 хүний халуун ус барих, ус түгээх 2 ш гүний худаг барих, машин техник нийлүүлэх, цэвэрлэх байгууламжид био цөөрмийн карт барих зэрэг ажлуудад хийгдсэн хөрөнгө оруулалт байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал гэж ангилсан байна. Зардлыг өмнөх онтой харьцуулахад нийт зардал 128.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, тээвэр шатахууны зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант онд 193.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 656.5 сая төгрөгийн газар эзэмших эрхийг биет бус хөрөнгөөр бүртгэж, орлого авсантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс нийт дүнгээр 472.0 сая төгрөгөөр нэмэгджээ.

Цахилгаан шугам сүлжээний газарт Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Цахилгааны шугамын шинэчлэл, алдагдал бууруулах” төслөөр 2009 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 2136.6 сая төгрөгийн зээл бүртгэлтэй бөгөөд тайлант онд өр төлбөр дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. ЦШСГ нь 2136.6 сая төгрөгийн төслийн урт хугацаат өр төлбөртэй бөгөөд ямар нэгэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрчээ.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд Өлгий сумын Сум хөгжүүлэх сангаас авсан 20.0 сая төгрөгийн зээл барагдаагүй урт хугацаат өглөгийг бүртгэж иржээ.

“Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын богино хугацаат өглөгийн үлдэгдэл 102.2 сая төгрөгийн, Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 266.1 сая төгрөг /аймгийн ОНХС-гаас 2014 онд олгосон 200.0 сая төгрөгийн зээл, иргэдээс урьдчилж авсан түрээсийн төлбөрийн 66.0 сая төгрөгийн өглөг/-ийн, Урт хугацаат өр төлбөрийн хувь хүмүүсийн зээлийн эхний үлдэгдлээс 138.0 сая төгрөг /иргэдээс павильоны анхны тавилтын үнийн урьдчилгаанд авсан/-ийн өр төлбөрийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд он дамжсан өглөгтэй бөгөөд тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өглөгийн данстай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ЦШСГ нь авлага 619.0 сая төгрөгөөр, богино хугацаат өглөг 78.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Сангийн яам “Суат” ХХК-ны урт хугацаат зээлийн үлдэгдлээс 331.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсвөөс суутган төлүүлсэнтэй холбоотой богино хугацаат өглөгийг 331.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 520.7 сая төгрөг болж, өмнөх оноос 2,344.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	69,733.7	36,514.7	(33,219.1)
Хуримтлагдсан үр дүн	70,580.3	40,016.1	(30,564.2)
Өмнөх үеийн үр дүн	42,778.1	161,178.0	118,399.9
Тайлант үеийн үр дүн	27,802.2	(121,161.9)	(148,964.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,598.0	15,342.7	(55,255.4)
Дүн	210,912.0	91,873.4	(119,038.6)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 33,219.1 сая, хуримтлагдсан үр дүн данс 30,564.2 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц данс 55,255.4 сая төгрөгөөр тус тус буурч, Засгийн газрын хувь оролцоо данс нийт дүнгээрээ 119,038.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5.11 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн 5-03/315 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 104,785.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,571.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баян-Өлгий аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн дараах байгууллагуудад албан шаардлага хүргүүлсэн. Аймгийн ИТХ 35.3 сая, Асрамжийн газар 24.3 сая, Санхүүгийн хяналт, аудитын алба 1.8 сая, Алтай сумын ИТХ 7.1 сая, Алтай сумын ЗДТГ 61.3 сая, Булган ЗДТГ 10.3 сая, Цагааннуур захирагчийн алба 5.8 сая, Булган сумын ОНХС 395.9 сая, Буянт сумын ОНХС 271.0 сая, Толбо сумын ОНХС 329.2 сая, Толбо ХХС 16.8 сая, Өлгий ОНХС 569.8 сая төгрөгийн, нийт 1728.3 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчил гаргажээ.
- Сум дундын ойн анги, Алтанцөгц, Баяннуур, Толбо, Өлгий сумын ЗДТГ, Алтанцөгц, Улаанхус сумдын ОНХС, Улаанхус сумын ХХС-ийн 54.2 сая төгрөгийн шилэн дансны зөрчилд 8 зөвлөмж хүргүүлсэн.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид 2 заалттай зөвлөмж хүргүүлсний хэрэгжилтийг давтан шалгахад 1 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн.
- Татан буугдсан “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэгдсэн нийт 506.3 сая төгрөгийн өр төлбөртэй холбоотой зөвлөмж биелэгдээгүй байна.

Хүснэгт №11 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	-	1	-	50%
Нийт дүн	2	-	1	-	50%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын өр, авлагын барагдалт, төсвийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналт, түүний үр дүнг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй, бусад алдаа зөрчил илрээгүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн зөвлөмж, акт, албан шаардлага:

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй, акт тогтоогдоогүй, албан шаардлага өгөгдөөгүй болно.

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар дүгнэж гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 42 төсвийн байгууллага, 29 тусгай сан /ОНХС, ХХС/, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 88 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 36 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж сумуудын ИТХ, Сум дундын ойн анги, Санхүүгийн хяналт, аудитын алба, Нийгмийн халамжийн сан, Асрамжийн газар, “Сансар” эмнэлэг, Хот тохижуулах алба, Өрхийн Эрүүл мэндийн төвүүд, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, сумын Хоршоо хөгжүүлэх сан зэрэг 52 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Нийт 36 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн. “Хязгаарлалтай”, “Сөрөг”, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан байгууллага гараагүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийтдээ 11,823.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, үүнээс 5,986.4 сая төгрөгийн алдааг залруулж, 4.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5050.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 782.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 25 заалттай зөвлөмж өгөгдсөн байна. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал гараагүй байна.

Хүснэгт №12: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

№	Байгууллага нэгжийн нэр	Байгууллагын тоо	Үүнээс		Алдаа зөрчлийн ангилал								Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн		Гаргасан дүгнэлт			
			Түүвэр	Дүгнэлт	Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга		Тоо	Дүн /төг/	Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Татгалзсан
					Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/						
1	ТШЗ	42	22	20	20	782.4	16	487.9	8	4.3	22	3,977.8	66	5,252.4	20			
2	ТБОНӨААН	3	1	2	2	-	4	343.5	-	-	5	1,665.6	11	2,009.1	2			
3	ТТЗ	43	29	14	3		9	4,218.8			8	343.1	17	4,561.8	14			
НИЙТ ДҮН		88	52	36	25	782.4	29	5,050.2	8	4.3	35	5,986.4	94	11,823.3	36	-	-	-

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								


БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар #107

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2018 оны А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг даргын орлогчид тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /Х.Арман/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Фестивал/, нарт зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг санхүүгийн тайлангийн аудит хариуцсан ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН

D:\bichig heregl2023\tushaal.doc

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан